

BASALTWOOL®
МОНГОЛ БАЗАЛЫТ ХК

**2023 оны хагас
жилийн үйл
ажиллагааны
тайлан**

Компанийн тухай



Ерөнхий мэдээлэл

Оноосон нэр:

Монгол Базальт ХК

Үйл ажиллагааны чиглэл:

Чулуун хөвөнгийн үйлдвэр, үйлдвэрийн хүчин чадал: Цагт 1.8 тн

Байгуулагдсан огноо:

2007

Хаяг:

Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Фламинго тауэр, 403
ТООТ

Вэбсайт, фэйсбүүк хаяг:

www.basaltwool.mn
Mongol Basalt JSC

Утас, и-майл хаяг:

75114444
monbasalt@rockwool.mn



Удирдлага, хүний нөөц

ТУЗ-ийн дарга:

Л.Ариунболд

Гүйцэтгэх захирал:

А.Энхгэрэл

Ажилчдын тоо:

84



Хувьцааны мэдээлэл

Хувьцааны симбол код:

MSE:MBW / 544

МХБиржид бүртгэгдсэн:

2018.04.05

Нийт гаргасан хувьцаа:

56,417,000 ширхэг

Компанийн танилцуулга



"МОНГОЛ БАЗАЛЪТ" ХК нь Монголын хүнд аж үйлдвэрийн салбараас анхны Байгаль орчин нийгэм засаглалын үнэлгээ /ESG/ хийлгэсэн, дэлхийн аж үйлдвэрийн IV хувьсгал, хөгжлийн тэргүүлэх чиглэлд судалгаа шинжилгээний ажлыг эрчимжүүлж, шинэ технологи, инновацийн шийдэл бүхий үйлдвэрлэлийг нэвтрүүлэн, хүн төрөлхтний өмнө тулгамдаж буй хүлэмжийн хий, агаарын бохирдол, эрчим хүчний зардал, дулааны алдагдлыг бууруулах чиглэлээр олон зорилтот төсөл хөтөлбөр амжилттай хэрэгжүүлж буй үндэсний томоохон үйлдвэрлэгч юм.

Бид галт уулын чулуулгийг чулуун хөвөн болгон хувиргаж, нийгэмд тулгарч буй уур амьсгалын өөрчлөлтийн томоохон сорилтуудыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах бүтээгдэхүүн үйлдвэрлэж, орчин үеийн амьдралыг баяжуулж, аюулгүй, эрүүл, уур амьсгалд илүү тэсвэртэй, тотвортой нийгмийг бий болгох шинэ боломжийг үргэлж эрэлхийлдэг.

Компанийн засаглал

Хувьцаа эзэмшигчдийн хурал

Компанийн 2023 оны хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2023 оны 04 сарын 17-ны өдөр Сүхбаатар дүүргийн 1-р хороо, фламинго тауэр 7 давхарт байрлах оффист 72.24%-ийн ирцтэй зохион байгуулсан ба хурлаар 2022 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд өгсөн ТУЗ-ийн дүгнэлтийг батлах, ТУЗ-ийн ердийн болон хараат гишүүдийг сонгох, ТУЗ-ийн гишүүдийн цалин урамшууллын хэмжээг батлах асуудлуудыг хэлэлцсэн.

Монгол Базальт ХК-ийн гүйцэтгэх удирдлагын баг нь оновчтой төлөвлөлт, чанартай гүйцэтгэлийг хэрэгжүүлж 2022 оны бизнес төлөвлөгөөний биелэлтийг давуулан ажилласан ба үүний илрэл нь нэгж хувьцаанд 20 төгрөгийн ногдол ашиг буюу нийт хувьцаа эзэмшигчдэд 1,1 тэрбум төгрөгийг ашиг болгон тараах боломж нөхцлийг бүрдүүлсэн гэж Төлөөлөн удирдах зөвлөлөөс дүгнэлээ.

Монгол Базальт ХК нь 2022 онд Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк-тай олон улсын техник, технологи, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан ба 2023 оны эхний улиралд ЕСБХБ-ны зөвлөх инженерүүдийг хүлээн авч уулзан инженер техникийн инновациор үйлдвэрлэлийн өртөгийг 20-30% буурууллаа. Уг зөвлөх үйлчилгээний хүрээнд олон улсын Байгаль Орчин, Нийгэм, Засаглалын /ESG/-ийн тогтвортой байдлын үнэлгээний тайланг Резилэйнс консалтинг сервис /RCS/ ХХК-аар хийлгэж, БОНЗ-ын үнэлгээний үр дүнгээр сайжруулах, тогтвортой байдлыг хангах ажлуудыг эхлүүлээд байна.

Төлөөлөн удирдах зөвлөл



Компанийн төлөөлөн удирдах зөвлөл 2023 оны 05 сарын 01-ний өдөр 100% ирцтэйгээр хуралдаж 2023 оны ТУЗ-ийн ажлын төлөвлөгөөг баталсан ба ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүнийг томилсон болно.

Мөн ТУЗ-ийн дэргэд эрсдэлийн удирдлагын хороог 5 гишүүнтэй байхаар шинээр байгуулж компанийн үйл ажиллагааны онцлог, бизнесийн чиглэлээс хамаарч хүлээж болох эрсдэлийн төрөл хэмжээ хязгаарыг тодорхойлох, илрүүлэх үнэлэлт өгч зөвлөмж гаргах чиг үүрэгтэйгээр ажиллаж байна.

ТУЗ-ийн дарга Л.Ариунболд
Нэр дэвшүүлэх хорооны дарга П.Нямдорж
Аудитын хорооны дарга Ч.Зоригтбаатар
Цалин урамшууллын хорооны дарга Ш.Энхтөр
Эрсдэлийн удирдлагын хорооны дарга Ч.Зоригтбаатар



Хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгогдсон ТУЗ-ийн гишүүд:

ТУЗ	Ердийн гишүүд						Хараат бус гишүүд		
Зураг									
Овог нэр	Л.Ариунболд	Г.Ганзориг	Б.Шаравсамбуу	П.Сайнбилэг	Хан гю бунг	А.Энхгэрэл	Ч.Зоригтбаатар	Ш.Энхтөр	П.Нямдорж
Мэргэжил	Инженер, Эдийн засагч	Цэргийн командлагч, Улс төр судлаач	Нягтлан бодогч, Эдийн засгийн ухааны доктор	Технологийн инженер, Санхүүч	Бизнесийн удирдлагын мастер	Үйлдвэр үйл ажиллагаа, Санхүү менежмент	Хуульч, Эдийн засагч	Эрх зүйч, Банкны удирдлага	Багш, Бизнесийн удирдлага
Ажлын туршлага	Хүнд аж үйлдвэрлэлийн салбарт 36 жил ажилласан. Монгол Базальт ХК-ийг үүсгэн байгуулагч	Батлан хамгаалах салбарт 43 жил ажилласан. 2016 оноос Монгол Базальт ХК-ийн шугам хоолойн дулаалгын төслийн удирдагч	Санхүү эдийн засгийн салбарт 58 жил ажилласан. Худалдаа бэлтгэлийн яамны сайд, улсын их хурлын гишүүнээр ажиллаж байсан.	Банк санхүүгийн салбарт 20 жил ажилласан. 2007-2018 онд Монгол Базальт ХК-ийн санхүү эрхэлсэн захиралаар ажиллаж байсан.	1999-2006 он Хьюндай-Салбарын дарга, 2006 оноос ГАҮЛИ ҮЦК-ийн гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.	2013-2017 он "Монгол Базальт" ХК-ийн Олон улсын төсөл хариуцсан захирал, 2018 оноос "Монгол Базальт" ХК-ийн Гүйцэтгэх захирал	27 жил хуульчаар ажилласан. 2008 оноос Лекс Коунсел ХХК-Гүйцэтгэх захирал	1997-2009 он Худалдаа Хөгжлийн банк, Хуульч 2013 оноос Монголын өмгөөлөгчдийн холбоо, Монголын хуульчдын холбоо-Өмгөөлөгч	ХХК-Захирал 2011-2012 он MWTS ХХК-Брокер 2013-2015 он Гацуурт трейд ХХК- Ахлах брокер 2015 он Монголын Хөрөнгийн бирж ТӨХК-Маркетингийн мэргэжилтэн
Хувьцаа эзэмшлийн хувь	35.7%	0%	0%	13.3%	0.10%	7%	0%	0%	0%
Ирц, оролцоо	100%	100%	100%	100%	Цахим 70%	100%	95%	90%	90%

Хувьцааны мэдээлэл



ХУВЬЦААНЫ ХАНШ

Хаалтын ханш
/2023.06.30/

212.49₮

-5.27




207.22₮

Өмнөх ханш
/2023.03.31/

Хувьцаа эзэмшигчид

■ 5%-иас дээш хувьцаа эзэмшигчид

■ 5%-иас доош хувьцаа эзэмшигчид



Тайлант хугацаанд хоёрдогч зах зээлд арилжаалагдсан нийт хувьцааны дээд ханш нь 242.48₮, доод ханш нь 196.28₮ бөгөөд 2023 оны хагас жилийн хаалтын ханш 207.22₮ байлаа.

Тайлант хугацаанд үнэт цаасны хоёрдогч зах зээлд сард дунджаар 311.5 мянган ширхэг буюу тайлант хугацааны туршид нийт 1,869 мянган ширхэг хувьцааг 403.4 сая төгрөгөөр арилжаалагдлаа.

5%-иас дээш хувьцаа эзэмшигчид:

№	Нэр	Нийт хувьцаанд эзлэх хувь
1	Л.Ариунболд	35.7%
2	П.Сайнбилэг	13.3%
3	А.Энхгэрэл	7%
4	А.Энхмаа	7%
5	А.Энхжин	7%

Гүйцэтгэх удирдлагын баг



Гүйцэтгэх захирал
А.Энхгэрэл



Дэд захирал
П.Батмөнх



Дотоод аудитор
Ц.Байгалмаа



Үйлдвэрийн дарга
П.Баасан-Очир



Ерөнхий менежер
Д.Сайнбаатар



Ерөнхий нягтлан
бодогч
Б.Болортуяа



Ерөнхий инженер
Х.Батдэлгэр




Ерөнхий механик
инженер
Ж.Сүхбаатар

Хүний нөөц


2019-2023 оны хооронд тогтвортой ажлын байрны өсөлт 35% байгаа ба шинээр базальт кассет сэндвич хавтангийн үйлдвэр ашиглалтанд оруулсанаар ажлын байрны тоо хэмжээ 2 дахин өснө. Нийт ажилтаны 90% нь дээд боловсролтой, 70% нь 3 жилээс дээш хугацаанд ажилласан нь хүний нөөцийн тогтвортой, чадварлаг баг бүрдсэнийг илтгэж байна. 2023 оны эхний хагас жилийн цалингийн сангийн хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 39% өссөн байна.




БОЛОВСРОЛЫН ТҮВШИН




АЖИЛЛАСАН ЖИЛ



АЖИЛЛАХ ХҮЧНИЙ ХАРЬЦУУЛАЛТ



ЦАЛИНГИЙН САНГИЙН ХАРЬЦУУЛАЛТ / САЯ ТӨГРӨГ



Бүтээгдэхүүн



БАЗАЛЬТ ЧУЛУУН ХӨВӨН

Дуу чимээ, дулаан тусгаарлагч барилгын материал



БАЗАЛЬТ СЭНДВИЧ ХАВТАН

Дуу чимээ, дулаан тусгаарлагч барилгын материал, 2 талдаа профил төмөртэй чулуун хөвөн хавтан



ТЕРМОБАЗАЛЬТ ОЁМОЛ ХӨНЖИЛ

Шугам хоолойн дулаалгын материал, дулаан, ус дамжуулах шугам хоолой дулаалахад тохиромжтой



ТЕРМОБАЗАЛЬТ ШУГАМ ХООЛОЙН ДУЛААЛГА

Яндан турба шугам хоолойн дуу чимээ, дулаан тусгаарлагч материал



ГРӨВҮҮЛ

Гидропоник хөрсгүй тариалалт, босоо хүлэмжний технологи, базальт чулуун хөвөн үндэс баригч



БАЗАЛЬТ ФАЙБЕР АРМАТУР

Базальт фибер арматур ган арматураас 2,5 дахин бэх, 4 дахин хөнгөн

Онцлох үйл явдал /I-р улирал/

Үзэсгэлэн арга хэмжээ

Улаанбаатар барилга 2023 үзэсгэлэнд оролцон шинээр хэрэгжүүлж буй базальт арматур, хэсэгчлэн угсрах сэндвич хавтан болон бусад бүтээгдэхүүний мэдээллийг барилгын салбарынханд болон олон нийтэд танилцууллаа.

Барилгачин группын зохион байгуулсан "Барилгын материал ханган нийлүүлэгчдийн чуулга" уулзалтад амжилттай оролцож бүтээгдэхүүн үйлчилгээгээ үзэсгэлэн гарган барилгын салбар болон олон нийтэд танилцууллаа.

"Хөгжлийн төлөө барилгачдын нэгдэл ТББ-аас зохион байгуулж буй "Барилгын салбарын сэргэлт" чуулга уулзалтад Монгол Базальт ХК инновацийн шийдлээр үнийн өсөлтийн эсрэг зогсож бүтээгдэхүүнийхээ үнийг 20-30% бууруулсан тухайгаа танилцууллаа.

BASALT HOCKEY CUP 2023

Хүүхдийн шайбтай хоккейн лигийн тэмцээнийг "Монголын ирээдүй болсон хүүхэд багачуудынхаа төлөө бид зүтгэнэ" уриан дор Мэргэн Хоккейн Академитай хамтран амжилттай зохион байгууллаа.



Онцлох үйл явдал /II-р улирал/

Үзэсгэлэн арга хэмжээ

Монгол Базальт ХК-ны удирдлагууд Замын Үдийн Гаалийн Газартай хамтран сургалт өдөрлөг зохион байгууллаа.

Монгол Базальт ХК Мишээл барилгын их дэлгүүрийн сургалт судалгааны төвөөр дамжуулан 300 иргэнд зөвлөгөө мэдээлэл хүргэж ажиллаа.

Монгол Улс дахь Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх үйлчилгээ (ГЕФФ) хөтөлбөрийн албан ёсны нээлтэд Монгол Базальт ХК уригдан онцлох бүтээгдэхүүн хөгжүүлэгч түнш байгууллагаар оролцлоо.

"Тогтвортой хөгжилд хамтдаа" уриан зохион байгуулаж буй BARILGA EXPO 2023" олон улсын үзэсгэлэн, ярмаг Монгол Базальт ХК хэрэглэгчдээ бүтээгдэхүүнийхээ үнийг 20-30% хүртэл хямдруулсан бэлэгтэйгээр оролцлоо

Ерөнхийлөгчийн ивээл дор "Тогтвортой хөгжилд эмэгтэйчүүдийн оролцоо" сэдвийн хүрээнд зохион байгуулагдсан Олон улсын эмэгтэй эрдэмтэд инженерүүдийн эрдэм шинжилгээний хурал (ICWSTEM)-ыг хамтран зохион байгуулж ерөнхий ивээн тэтгэгчээр ажиллаа.



Онцлох үйл явдал /II-р улирал/

Гар зургийн уралдаан 2023

Монгол Базальт ХК жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг гар зургийн уралдаанаа НОГООН ХОТ МИНИЙ ИРЭЭДҮЙ сэдвээр 6-12 насны хүүхэд багачуудын дунд зохион байгууллаа. Нийт 170 бүтээл ирсэнээс 2 насны ангилалд 8 бүтээлийг шалгаруулсан төдийгүй олны таашаал хүртсэн 12 бүтээлүүдийг шалгаруулан үзэсгэлэн гаргаж, батламж гарын бэлэг гардууллаа.



Facebook азтан

2023 оны МОНГОЛ БАЗАЛТ ХК-ийн FACEBOOK азтан СХД-ийн 43-р хорооны иргэн С.МӨНХЦЭЦЭГ-тэй шагналыг нь гардууллаа. Азтанг 2023 оны 05 сарын 08ны өдрөөс 05 сарын 29-ны өдөр хүртэл 21 хоногийн хугцаанд явуулж 469 хүнээс санамсаргүй байдлаар 1 азтанг сонгож тодруулан 2,500,000 төгрөгний дулаалгын материал авах эрхийн бичгийг гардуулан өглөө.



Азийн Физикийн Олимпиадаас Хүрэл медаль хүртсэн Л.Дөлгөөн, 11-р сургуулийн физикийн багш Хатанбаатар, захирал Хишигбаяр нарыг хүлээн авч уулзан баяр хүргэн мөнгөн шагнал, Юнимат эдүкэйшн зохион бүтээх төвийн сийлбэрийн машинаар урамшууллаа.



Хамтын ажиллагаа



European Bank
for Reconstruction and Development



2023 оны 2-р улиралд чанарын менежментийн тогтолцоо MNS ISO 9001 : 2015, Байгаль орчны менежментийн тогтолцоо MNS ISO 14001 : 2015, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн менежментийн

тогтолцоо MNS ISO 45001 : 2018 стандартуудыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр ажиллаж байгаа ба зөвлөх үйлчилгээний Ризилэйнс консалтинг сэрвиз ХХК-тай хамтран ажиллаж байна.



Европын сэргээн босголт хөгжлийн банк (ЕСБХБ), Уур амьсгалын ногоон сан (УАНС), Японы- ЕСБХБ-ны хамтын ажиллагааны сан нар хамтран Уур амьсгалын нөлөөллийг бууруулах, дасан зохицоход туслах дэвшилтэт ногоон технологид хөрөнгө оруулах хүсэлтэй хувь хүн, бизнес эрхлэгчдийг 137 сая ам.долларын ногоон зээлийн шугамыг орон нутгийн санхүүгийн байгууллагуудаар дамжуулан дэмжин ажиллаж буй Монгол Улс дахь Ногоон эдийн засгийг санхүүжүүлэх үйлчилгээ (ГЕФФ) хөтөлбөрийг хэрэгжүүлдэг бөгөөд хөтөлбөрийн албан ёсны нээлтэд Монгол Базальт ХК уригдан онцлох бүтээгдэхүүн хөгжүүлэгч түнш байгууллагаар оролцлоо.

Бид Хаан Банк-тай хамтран Ногоон барилга барих иргэд ААН-үүдэд зориулсан онцгой бүтээгдэхүүн гаргаж байгаа тул хэрэглэгч худалдан авагч нар хэрэгцээ мэдээллээ манайд хандаж өгсөнөөр бид хамгийн хэмнэлттэй шийдэлийг санал болгож байна.



НОГООН ТӨСӨЛ GROWOOL



Чулуун хөвөн ашиглан гидропоник технологиор тариалалт хийх нь байгаль цаг уураас хараат бус жилийн дөрвөн улирал тогтвортой ургац хураах боломжыг бүрдүүлэх болно.

Монгол Базальт ХК-ийн хамт олон анхны монгол хэл дээрх хөрсгүй тариалалтын гидропоник технологийн зааварчилгаа, гарын авлага номыг бэлтгэн, 2021 оны 11 сард худалдаанд гаргасан.

Монгол Базальт ХК нь 2019 оноос GROWOOL /ургамал тарих чулуун хөвөн/ старт апыг бойжуулан хадгалалт тээвэрлэлтээс үүсэх хүнсний ногооны хаягдалыг багасгах, усны хэрэглээ бага тариалалтын технологийг нэвтрүүлэх, хуурай сэрүүн уур амьсгалтай Монгол орны нөхцөлд байгаль цаг уураас хараат бус жилийн турш тогтвортой тариалалт хийх боломжтой шинэ технологи болох гидропоник технологийн талаар сургалт зөвөлгөө, гарын авлага, мэдээлэлийг иргэд аж ахуй нэгж, нийгэмд түгээн ажиллаж байна.



Тогтвортой хүнсний үйлдвэрлэл

Монгол улсын хүнсний ногооны 80%-г импортын бүтээгдэхүүн эзлэж байна. COVID-ын нөлөөгөөр монгол улсад өргөн хэрэглээний хүнсний ногооны үнэ нэмэгдэж, хомсдол бий болж буй энэ цаг үед бид иргэн бүр хүнсний ногоогоо өөрөө ургуулах боломжтойг сурталчилан таниулж байна.

Монгол улсын цэвэр усны хэрэглээний 12%-г усалгаатай тариалан буюу газар тариаланд ашигладаг бөгөөд базальт чулуун хөвөн ашигласнаар газар тариаланд ашиглаж буй усыг 80-90%, тариалалтын талбайн хэмжээг 70% хүртэл хүртэл бууруулах бүрэн боломжтой юм.

Мөн жилийн дөрвөн улиралд уур амьсгал, цаг агаарын нөлөөлөлөөс шалтгаалахгүйгээр тогтвортой хүнс үйлдвэрлэх боломжтой тул тогтвортой хөгжлийн зорилтын 2, 6 болон 15 дугаар зорилтуудыг бүрэн хангаж чадсан **НОГООН** төсөл юм.





SUSTAINABLE DEVELOPMENT GOALS

17 PARTNERSHIPS FOR THE GOALS

SDG 17: engage in effective collaboration

SDG 13: Increase the production of buildings and structures that emit less carbon dioxide

SDG 7: Facades of industrial and office buildings have been renovated and improved energy efficiency

SDG 6: A used water resource fund was established, water reuse was introduced, and gray water was used in the industry

SDG 13: The filter system of the outlet pipes of the factory has been improved again and carbon dioxide emissions have been brought to a lower level than the standard

SDG 8: Improved safety and reduced downtime

SDG 9: Increase the strength and fire resistance of buildings

SDG 8: Promote sustainable jobs and economic growth

SDG 13: To activate the production of carbon-efficient buildings and structures




SDG 11: Promote affordable housing and energy efficiency

SDG 7: Increase energy-efficient buildings and production

SDG 6: Reduce the use of irrigation water

SDG 2: Building sustainable food production


ЭРЧИМ ХУЧНИЙ ХЭРЭГЛЭЭ



SDG 12: Efficient production without waste



SDG 3: Increasing noise isolation buildings



GROWOOL SUSTAINABLE GROWING

Sustainable Development Goals

ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



ЕСБХБ-ны олон улсын зөвлөх үйлчилгээ:

Монгол Базальт ХК нь 2022 онд ЕСБХБ-тай олон улсын техник, технологи, санхүүгийн зөвлөх үйлчилгээний гэрээ байгуулсан ба 2023 оны эхний улиралд ЕСБХБ-ны зөвлөх инженерүүдийг хүлээн авч уулзан инженер техникийн инновациор үйлдвэрлэлийн өртөгийг 20-30% бууруулах боломжтой болсон ба бүтээгдэхүүний үнийг 20-30% буурууллаа.

↑ **Технологийн Инноваци** = **Үйлдвэрлэлийн өртөг** ↓



ШИНЖЛЭХ УХААН ТЕХНОЛОГИЙН ИХ СУРГУУЛЬ БАРИЛГА, АРХИТЕКТУРЫН СУРГУУЛИЙН, Барилгын материал үйлдвэрлэл технологийн ангийн 1, 2-р курсын оюутанууд МОНГОЛ БАЗАЛТ ХК-ийн үйлдвэрийн технологи болон үйл ажиллагааны зарчимтай танилцах дадлага сургалт хийлээ.

2023 оны хагас жилийн байдлаар 610,2 тонн хөвөн үйлдвэрллээ. Термобазальт шугам хоолойн дулаалгын цехэд нийт 2338 метр шугам, яндан хоолойн дулаалга хийж гүйцэтгэлээ. Чулуун хөвөн дулаан тусгаарлагч материалын үйлдвэрт их бүтээн байгуулалт засвар шинэчлэлийн ажил өрнүүлж, тоног төхөөрөмжийн туршилт тохируулгын ажлуудыг хийж гүйцэтгэлээ.

“Монгол Базальт” ХК нийт ажилтнуудаа 2023/06/24-ны өдөр 14-16 цагийн хооронд гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх онол, практикийн сургалтад хамрууллаа. Ажилтан албан хаагчдыг урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамрагдахыг уриалан 2023 оны 05 сард нийт ажилчдыг нэгдсэн байдлаар хамрууллаа.



САНХҮҮ БАЙДЛЫН ТАЙЛАНГИЙН ГОЛ ҮЗҮҮЛЭЛТҮҮД



Монгол Базальт ХК нь 2023 оны эхний хагас жилд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажиллалаа.

Үйлдвэрлэлийн шинэчлэл инновацийн үр дүнд чулуун хөвөн хавтангийн борлуулалтын үнээ 20%-30% бууруулан хэрэглэгчдэд хүргэж байна.

Дотоод хяналт

Дотоодын хяналтын нэгжийг жил бүр гүйцэтгэх захиралын тушаалаар томилдог бөгөөд тухайн жилийн дотоод хяналтын төлөвлөгөө болон тайланг боловсруулан гүйцэтгэх захирал, ТУЗ-д тайлаганах хэлбэрээр үйл ажиллагаа явуулж байна.

2023 онд томилогдсон дотоод хяналтын нэгж 2023 оны дотоод хяналтын ажлын төлөвлөгөөг боловсруулан батлуулж, хэрэгжилтийг хангахаар ажиллаж байна.

Борлуулалт / мян.төгрөг




Санхүүгийн бусад үзүүлэлтүүдийг компанийн хагас жилийн санхүүгийн тайлангаас үзнэ үү.

Олгосон ногдол ашиг

Он	Нийт ногдол ашиг	Цэвэр ашигт эзлэх %	Нэгж хувьцаанд ногдох /₮/	Ногдол ашгийн өгөөжийн %
2019	225,668,000.00	68%	4.00	2%
2020	162,480,960.00	100%	2.88	2%
2021	964,166,530.00	60.2%	17.09	10%
2022	1,128,340,000.00	53.4%	20	9%

Ногдол ашгийн өсөлт /₮/





БОРЛУУЛАЛТ



Монгол Базальт ХК нь 2023 оны эхний улиралд зах зээлийн эрэлт хэрэгцээг бүрэн хангах зорилгоор их бүтээн байгуулалтыг өрнүүлж үйлдвэрлэлийн шугам дамжлагаа хүчитгэн ажилласаны үр дүнд 83,000 орчим боодол бүтээгдэхүүн борлуулсан байна.

Нийт борлуулсан бүтээгдэхүүний 36.97%-ийг базальт лайт, 23%-ийг базальт хауз, 20.4%-ийг базальт вэнт фасад, 19.5%-ийг базальт техно стандарт марк тус тус эзэлж байна.





BASALTWOOL®

Тогтвортой хөгжлийг
эрчим хүчний бодит хэмнэлтээр
Насан туршийн баталгаа

